



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 9/46

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулж,
сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандарт хэмжил зүйн газарт 2023 оны 03 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Массын хэмжлийн төрлөөр хэмжилзүйн мэргэшүүлэх сургалт”-д хамрагдсан Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн химич инженер Л.Отгонжаргалын сургалтын төлбөр 120,000 (нэг зуун хорин мянга) төгрөгийг зохих журмын дагуу зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

2. Сургалтад хамрагдсан үр дүнд хяналт тавьж, сургалтын тайланг дүгнэж ажиллахыг Оношилгоо, хэмжил зүйн лаборатори (Г.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0372